

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/60/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас:261885 Цахим хаяг: nyamtsetsegi@audit.gov.mn Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.2 Албан шаардлага	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТУХ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УБХТАЗТТ	Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.30 № 06/855

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн хүрээнд тайлант онд Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн цогц тогтолцоог бий болгох 4 бодлогын баримт бичиг, стратеги, төлөвлөгөө боловсруулагдан, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэн батлагдсан нь Улаанбаатар хотын авто зам, авто зогсоол, нийтийн тээврийн салбарыг нэгдсэн бодлого менежментээр удирдан, шат дараатай үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий бичиг баримт болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлбэ голын авто зам болон Нарны замын зүүн өргөтгөлийн 2 гэрээт ажлын техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах болон барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 онд анх байгуулснаас хойш 2024, 2025 онуудад гэрээний үнэ нэмэгдсээр 17.9 хувь буюу 993,000.0 мянган төгрөгөөр өсгөж, нийт үнийн дүнгийн 75.55 хувь буюу 4,804,293.5 мянган төгрөгийг хүлээн авсан байна. Гэтэл авто зам барих 2 төсөл арга хэмжээ нь эхлэл төдий барилгын ажил эхлээгүй байна.

Бусад асуудал

Төсөл нь 2026 онд дуусах гэрээтэй байтал тайлант оны байдлаар 11.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төслийг батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлээгүй, төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэх нэгж хангалтгүй ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,397,396,698.24	16,220,492,300.95
31	Мөнгөн хөрөнгө	15,395,885,602.63	16,220,415,056.38
	Төрийн сангийн харилцах /төгрөг/	2,813,714,655.71	2,496,409,894.40
3122	Гадаад валют	12,582,170,946.92	13,724,005,161.98
31221	Төрийн сангийн харилцах /валют/	12,582,170,946.92	13,724,005,161.98
33	АВЛАГА	1,511,095.61	77,244.57
33402	ХХОАТ, НДШ- ийн авлага	17,360.66	17,360.66
33500	Бусад авлага	1,493,734.95	59,883.91
33510	Байгууллагаас авах авлага	1,057,705.45	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	436,029.50	59,883.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	133,927,351.13	80,562,985.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	133,927,351.13	80,562,985.28
39200	Биет хөрөнгө	124,913,652.50	74,049,286.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(582,387.48)	(4,010,958.90)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	245,641,917.79	256,201,457.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(190,811,873.35)	(243,902,628.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,972,119.34	78,866,819.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,306,123.80)	(25,105,402.63)
39300	Биет бус хөрөнгө	9,013,698.63	6,513,698.63
39301	Програм хангамж	12,500,000.00	12,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,486,301.37)	(5,986,301.37)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,531,324,049.37	16,301,055,286.23
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	62,794.26	62,794.26
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	62,794.26	62,794.26
41300	Өглөг	62,794.26	62,794.26
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	62,794.26	62,794.26
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	15,531,261,255.11	16,300,992,491.97
51	Засгийн газрын хувь оролцоо	15,531,261,255.11	16,300,992,491.97
51200	Хуримтлагдсан үр дүн	15,531,261,255.11	16,300,992,491.97
51210	Өмнөх үеийн үр дүн	2,443,073,399.73	15,531,261,255.11
51220	Тайлант үеийн үр дүн	13,088,187,855.38	769,731,236.86
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,531,324,049.37	16,301,055,286.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	20,831,266,451.97	30,130,901,499.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,831,266,451.97	30,130,901,499.42
120	Нийтлэг татварын бус орлого	17,925,920,109.20	27,455,419,162.13
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэх	17,925,920,109.20	27,439,550,548.73
120009	Бусад орлого	8,963,250.00	15,868,613.40
122	Тусламжийн орлого	2,896,383,092.77	2,675,482,337.29
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	16,532,255.52	-
122021	Буцалтгүй тусламжийн санхүүжилт	2,879,850,837.25	2,675,482,337.29
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,825,377,399.70	29,908,227,199.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,825,377,399.70	29,908,227,199.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,825,377,399.70	29,908,227,199.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	765,615,361.67	872,278,744.89
210101	Үндсэн цалин	765,615,361.67	872,278,744.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,711,754.72	101,292,318.95
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	90,711,754.72	101,292,318.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,647,800.00	144,000,000.00
210304	Байрны түрээс	119,647,800.00	144,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,376,789.24	28,540,650.76
210401	Бичиг хэрэг	16,114,866.00	17,727,710.00
210402	Тээвэр, шатахуун	8,964,647.33	10,529,340.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,538,025.00	198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,759,250.91	85,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,213,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	7,688,500.00
210604	Урсгал засвар	-	7,524,750.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,350,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	1,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,701,083,736.68	28,678,733,629.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж-Зөвлөх үйлчилгээ	6,662,629,356.14	28,646,621,773.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,200,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	795,600.00	421,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,168,000.00	566,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	21,600,363.64	15,131,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	690,416.90	692,535.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,941,957.39	66,818,605.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,941,957.39	66,818,605.85
213	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	13,005,889,052.27	222,674,299.61
2132	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	82,298,803.11	547,056,937.25
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	82,298,803.11	547,056,937.25
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	13,088,187,855.38	769,731,236.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	18,934,477,369.46	27,455,211,628.13
12	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,934,883,359.20	27,455,211,628.13
1200044	Гадаадын тусламжийн санхүүжилт	17,925,920,109.20	27,439,343,014.73
120009	Бусад орлого	8,963,250.00	15,868,613.40
121	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	999,594,010.26	-
122002	Хандив тусламж /гадаад/	999,594,010.26	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,861,268,595.11	27,177,739,111.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,861,268,595.11	27,177,739,111.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,861,268,595.11	27,177,739,111.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	764,881,915.51	872,278,744.89
210101	Үндсэн цалин	764,881,915.51	872,278,744.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,711,754.72	101,292,318.95
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	90,711,754.72	101,292,318.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,647,800.00	144,000,000.00
210304	Байрны түрээсийн хөлс	119,647,800.00	144,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,585,641.91	27,911,310.00
210401	Бичиг хэрэг	16,114,866.00	17,727,710.00
210402	Тээвэр, шатахуун	13,738,000.00	9,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,538,025.00	198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,194,750.91	85,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,978,063.00	28,667,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,694,745.00	10,559,540.00
210602	Тавилга	6,283,318.00	2,894,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	7,688,500.00
210604	Урсгал засвар	-	7,524,750.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,350,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	1,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,817,463,419.97	26,002,239,247.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,783,177,039.43	25,970,334,926.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,200,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	795,600.00	421,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	566,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	21,600,363.64	15,131,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	690,416.90	485,001.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,073,208,774.35	277,472,516.50
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	82,298,803.11	547,056,937.25
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	82,298,803.11	547,056,937.25
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	13,155,507,577.46	824,529,453.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,240,378,025.17	15,395,885,602.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,395,885,602.63	16,220,415,056.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,443,073,399.73	2,443,073,399.73
9	Тайлант үеийн үр дүн	-	-	13,088,187,855.38	13,088,187,855.38
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	15,531,261,255.11	15,531,261,255.11
19	Тайлант үеийн үр дүн	-	-	769,731,236.86	769,731,236.86
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	16,300,992,491.97	16,300,992,491.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Татаас санхүүжилтийн орлого	182,866,510,400.00	30,115,032,886.02	(152,751,477,514.02)	16.4
13	Тусламж, санхүүжилтийн орлого	182,866,510,400.00	30,115,032,886.02	(152,751,477,514.02)	16.4
1200044	Зээлийн санхүүжилт	176,077,234,100.00	27,439,550,548.73	(148,637,683,552.73)	15.6
	Буцалтгүй тусламж	6,789,276,300.00	2,675,482,337.29	(4,113,793,962.71)	39.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,733,964,063.00	29,854,025,959.20	(879,938,103.80)	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,733,964,063.00	29,854,025,959.20	(879,938,103.80)	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,318,964,063.00	1,207,404,185.46	(111,559,877.54)	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	938,712,000.00	872,278,744.89	(66,433,255.11)	92.9
210101	Үндсэн цалин	938,712,000.00	872,278,744.89	(66,433,255.11)	92.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,339,875.00	101,292,318.95	(16,047,556.05)	86.3
210201	Тэтгэврийн даатгал	117,339,875.00	101,292,318.95	(16,047,556.05)	86.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,000,000.00	144,000,000.00	(6,000,000.00)	96.0
210304	Байрны түрээс	150,000,000.00	144,000,000.00	(6,000,000.00)	96.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,012,188.00	27,911,310.00	(8,100,878.00)	77.5
210401	Бичиг хэрэг	18,600,000.00	17,727,710.00	(872,290.00)	95.3
210402	Тээвэр, шатахуун	10,012,188.00	9,900,000.00	(112,188.00)	98.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,400,000.00	198,000.00	(4,202,000.00)	4.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	85,600.00	(2,914,400.00)	2.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,900,000.00	31,790,211.62	(7,109,788.38)	81.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,559,540.00	10,559,540.00	-
210602	Тавилга	-	2,894,700.00	2,894,700.00	-
210603	Хөдөлмөр хамгаалал	10,000,000.00	7,688,500.00	(2,311,500.00)	76.9
210604	Урсгал засвар	28,900,000.00	10,647,471.62	(18,252,528.38)	36.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,000,000.00	30,131,600.00	(7,868,400.00)	79.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	23,000,000.00	15,131,600.00	(7,868,400.00)	-
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	29,415,000,000.00	28,646,621,773.74	(768,378,226.26)	97.4
2200	Дотоод эх үүсвэрээр	29,415,000,000.00	28,646,621,773.74	(768,378,226.26)	97.4
220001	Барилга байгууламж	11,000,000,000.00	22,921,446,626.03	11,921,446,626.03	208.4
	Зөвлөх үйлчилгээ	18,415,000,000.00	5,725,175,147.71	(12,689,824,852.29)	31.1
101	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,395,885,602.63	15,395,885,602.63	-
20	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,220,415,056.38	16,220,415,056.38	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20	17	(3)	-
620001	Удирдах ажилтан	2	2	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	18	15	(3)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд Зээлийн хэлэлцээр 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдөр төслийг санхүүжүүлэх зорилгоор Зээлийн гэрээ байгуулсан, Монгол Улсын Их Хурлаар 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр соёрхон батлагдсан. Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл нь 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжинэ.

Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр төсөлд нэмэлт санхүүжилт олгох буцалтгүй тусламжийн гэрээ байгуулсан байна.

Төслийн зорилго нь: Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн цогц тогтолцоог бий болгох, сонгогдсон гудамж замуудын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, авто замын аюулгүй байдлыг сайжруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байх асуудлуудыг шийдвэрлэхэд оршино.

Төслийн үндсэн зорилтын хүрээнд 3 бүрэлдэхүүн хэсгийн дагуу үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- I. Иж бүрэн гудамж, зам байгуулах ажил
 - 1.1. Цогц гудамж замын ажлууд (Complete street);
 - 1.2. Тээврийн ухаалаг систем;
 - 1.3. Ухаалаг авто зогсоолын систем (Smart parking).
- II. Тогтвортой нийтийн тээвэр
 - 2.1. Төслийн гудамж зам дагуух автобусны эгнээ болон нийтийн тээврийн зогсоол тохижилт;
 - 2.2. Автобусны удирдлагын системийн хөгжүүлэлт болон эрэлтэд суурилсан нийтийн тээврийн төлөвлөлт.
- III. Авто зам, тээврийн төлөвлөлтийн үр дүнтэй институтууд
 - 3.1. Зам, тээврийн стратегийн судалгаа;
 - 3.2. Чадавх бэхжүүлэлт болон төсөл хэрэгжилтийн дэмжлэг гэсэн 3 бүрэлдэхүүн хэсгээр хэрэгжиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авто замын тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Хөдөлмөрийн дотоод журам;
- УБХТАЗТТ-ийн засаглалын төлөв байдлын үнэлгээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах төслийн зохицуулагчийн тушаал;

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 769,731.3 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,395,885.6	16,220,415.1	824,529.5
Авлага	1,511.1	77.2	(1,433.9)
Үндсэн хөрөнгө	133,927.3	80,563.0	(53,364.3)
Нийт хөрөнгө	15,531,324.0	16,301,055.3	769,731.3
Өр төлбөр	62.8	62.8	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,531,261.2	16,300,992.5	769,731.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,531,324.0	16,301,055.3	769,731.3

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 824,529.5 мянган төгрөгөөр өссөн нь зээл тусламжийн санхүүжилтээс 280,799.5 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн, ханшийн тэгшитгэлээр 547,056.9 мянган төгрөгийн олз бүртгэсэн, төрийн сангаас иений ханшийн зөрүүгийн буцаалтад 804.5 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн орлогоос 15,868.6 мянган төгрөг орж ирсэнийг тус тус бүртгэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 1,433.9 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага 1,057.7 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 376.1 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 53,364.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 13,454.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 66,818.6 мянган төгрөгийг бүртгэснээс голлон шалтгаалсан.

Засгийн газрын хувь оролцоо 769,731.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төслийн санхүүгийн тайланд 12,500.0 мянган төгрөгийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой программ бүртгэлтэй бөгөөд жилийн үйлчилгээний төлбөрт 2,000.0 мянган төгрөгийг төлсөн байна. Мөн цахим архивын программ, хурал болон менежментийн

программ, домайн usut.mn программ болон антивирус хэрэглээний программ хангамжуудад тайлант онд 8,131.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөс 182,796,954.2 мянган төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөс 5,553,288.9 мянган төгрөг, нийт зарлагыг 188,350,243.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн удирдах хороо санхүүгийн төлөвлөгөөг 182,866,510.4 мянган төгрөг байхаар баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сангийн сайдын 2024.12.30-ны өдрийн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсэн 01/10803 тоот албан бичигт Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүжилтийг 19,467,700.0 мянган төгрөг байхаар чиглэл хүргүүлсэн ч тайлант онд Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 29,853,429.0 мянган төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг Сангийн ямаар баталгаажуулж гүйцэтгэлийг хангаж ажилласан.

Төслийн төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү их байгаа үндсэн шалтгаан нь тайлант онд зам барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер амжилтгүй болсон тул тендерийг дахин зарласан, мөн газар чөлөөлөлтийн ажил удааширнаас төлөвлөсөн ажил хугацаандаа эхлээгүйтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 29,853,429.0 мянган төгрөг буюу 16.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	70207-Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр	182,866,510.4	29,853,429.0	153,013,081.4	16.4	
2	80104 Гадаадын зээлээр хэрэгжүүлэх ажил	182,866,510.4	29,853,429.0	153,013,081.4	16.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Тухайлбал:

- Тус байгууллагын ажилчид нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх,

хяналт тавих, үнэлэх” журмын дагуу хөдөлмөрийн гэрээнд тулгуурлан цалин хөлсийг тооцдог тул орон тооны цомхотголд хамаарахгүй.

- Хөдөлмөрийн гэрээнд унаа хоолны хөнгөлөлт тусгагддаггүй тул унаа хоолны хөнгөлөлтийн зардал гардаггүй.
- Тайлант онд гадаад томиллолт, сургалт, семинар, хурал зөвлөгөөн, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант онд 3 хөтөлбөрийн 20 арга хэмжээнд зээлээс 176,077,234.1 мянган төгрөг, буцалтгүй тусламжаас 6,789,276.3 мянган төгрөг, нийт 182,866,510.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр зээлээс 26,569,869.7 мянган төгрөг, буцалтгүй тусламжаас 3,284,993.1 мянган төгрөг, нийт 29,854,862.8 мянган төгрөг буюу 16.3 хувьтай байна.

Хэрэгжилт дутуу, хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдал: Өнөр хороолол, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, зам, барилгын ажлын хувьд зам хаах, сэтлэх зэрэг холбогдох зөвшөөрлүүд шат дамжлага ихтэй байдлаас шалтгаалан, Нарны замын тендер амжилтгүй болсноос дахин зарлагдсан, Сэлбэ голын замын газар чөлөөлөлтийн нөхөх олговрын үнэлгээ хийлгэх, зөвшилцөх ажил болон биет нүүлгэн шилжүүлэлт гэх мэт тооцоолоогүй нөхцөл байдлаас үүдэн хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэг жих хугацаа	Хүрэх үр дүн 2025 он	Хэрэг жилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
Бүрэлдэхүүн 1.1. Цогц гудамж замын ажлууд						
1	Үйлдвэрчний эвлэлийн гудамж болон Өнөр хорооллын гудамжийг цогц гудамж зам болгон хөгжүүлэх зам, барилгын ажил	2025 - 2026	Өнөр хорооллын гудамж замын гүйцэтгэлийг 80%, Үйлдвэрчний эвлэлийн гудамж зам, барилгын ажлыг 40%-д хүргэнэ.	41.2%	27,970,073.8	11,515,734.9
2	Өнөр хорооллын гудамж (2.8 км), Үйлдвэрчний эвлэлийн гудамж (5.6 км)-ийг Цогц гудамж зам болгон хөгжүүлэх, шинэчлэх ажлын зураг төсөл болон барилгын ажилд хяналт тавих	2025 - 2026	Зам барилгын ажлын бүх үе шатанд техник технологийн хяналтын 60%-ийг хийнэ.	43.8%	981,412.8	429,626.6
3	Нарны замын зүүн өргөтгөх (4 км) зам барилгын ажил	2025 - 2026	Тендер шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Зам, барилгын ажлыг 40%-д хүргэнэ.	-	11,358,748.8	-
4	Нарны замын газар чөлөөлөлт	2025	Нөлөөлөлд өртсөн этгээдэд нөхөх олговрыг олгосон байна. Биет нүүлгэн шилжүүлэлтийг	27.7%	36,848,322.0	10,209,158.8

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			гүйцэтгэн, трассыг бүрэн чөлөөлөх.			
5	Сэлбэ голын баруун эргээр шинэ (2.5 км)-ээр барих зам, барилгын ажил	2024 - 2025	Тендер шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Зам, барилгын ажлыг 60%-д хүргэнэ.	4.5%	26,368,524.0	1,196,552.9
6	Яармагийн шинэ (8.3 км)-ээр барих зам, барилгын ажил	2025 - 2026	Тендер шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Зам, барилгын ажлыг 10%-д хүргэнэ.	-	14,029,407.0	-
7	Нарны замын зүүн өргөтгөх ажил (4 км), Сэлбэ голын баруун эргээр шинэ (2.5 км)-ээр зам барих ажлын ТЭЗҮ, зураг төсөл болон барилгын ажилд хяналт тавих	2025 -2026	Зам барилгын ажлын бүх үе шатанд техник технологийн хяналтын 50%-ийг хийнэ.	36.7%	2,254,860.4	828,460.2
8	Яармагийн шинэ зам (8,3 км), Улаанхуарангийн өргөтгөл (4,0 км) зам барих ажлын ТЭЗҮ, зураг төсөл болон барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	2024 - 2026	Замын зураг, төслийг боловсруулж, тендерийн бичиг баримтыг боловсруулсан байна. Зам барилгын ажлын бүх үе шатанд техник технологийн хяналтын 10%-ийг хийнэ.	42,7%	2,392,544.6	1,021,101.4
Бүрэлдэхүүн 1.2. Тээврийн ухаалаг систем						
9	Замын хөдөлгөөний хяналтын систем болон удирдлагын ерөөний тоног төхөөрөмж, техник хангамж, программ хангамжийн лиценз бүхий багц худалдан авалт	2025 - 2026	Тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан байна. Системийн хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалтын ажлын 80% хийгдсэн байна.	-	32,302,598.1	-
10	Тээврийн ухаалаг системийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	2023 - 2025	ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл болон тендерийн бичиг баримт боловсруулагдсан байна.	-	472,358.3	-
Бүрэлдэхүүн 1.3. Ухаалаг авто зогсоолын систем						
11	Авто зогсоолын удирдлагын ухаалаг системийг ашиглалтад оруулж, нэвтрүүлэх худалдан авалт	2025 - 2026	Тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан байна. Системийн хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн	-	19,625,957.2	-

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			нийлүүлэлт, суурилуулалтын ажлын 60% хийгдсэн байна.			
12	Авто зогсоолын стратеги болон менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ	2023 - 2025	Авто зогсоолын бодлого, стратеги болон менежментийн төлөвлөгөө батлагдсан байна.	90.9%	731,239.7	664,608.2
Бүрэлдэхүүн 2.2. Автобусны удирдлагын системийн хөгжүүлэлт болон эрэлтэд суурилсан нийтийн тээврийн төлөвлөлт						
13	Нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	2025	Нийтийн тээврийн удирдлагын төвийн шинэчлэлийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулагдсан байна.	21.2%	1,298,920.3	275,163.2
Бүрэлдэхүүн 3.1. Зам, тээврийн стратегийн судалгаа						
14	Улаанбаатар хотын тогтвортой зам, тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ	2023 - 2025	Тогтвортой зорилт хөдөлгөөний стратеги болон стратегийн төлөвлөгөө батлагдсан байна.	77.0%	983,840.1	757,673.9
15	Улаанбаатар хотын Нийтийн тээврийн урт болон дунд хугацааны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (стратеги) боловсруулах зөвлөх үйлчилгээ	2024 - 2025	Нийтийн тээврийн стратеги, стратегийн төлөвлөгөө боловсруулагдаж, батлагдсан байна.	82.8%	1,080,714.0	895,340.1
16	Замын хөдөлгөөний хурдны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ	2024 - 2025	Замын хөдөлгөөний хурдны менежментийн төлөвлөгөө батлагдсан байна.	51.7%	692,836.3	357,860.1
17	Зам, тээврийн ослын мэдээллийн платформ нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ	2024 - 2025	Зам, тээврийн ослын бүртгэл, мэдээллийн платформ хөгжүүлж, суурилуулсан байна.	11.6%	1,071,353.1	124,394.4
Бүрэлдэхүүн 3.2. Чадавх бэхжүүлэлт болон төсөл хэрэгжилтийн дэмжлэг						
18	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг дэмжих зөвлөх үйлчилгээ	2024 - 2026	Сангийн сайдын баталсан хойшлуулах төслийн жагсаалтад орсон тул цуцлагдсан.	-	338,058.0	-
19	Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөх үйлчилгээ	2023 - 2026	2025 оны төслийн хөгжлийн зорилтуудын хэмжилтийг хийж, дата мэдээлэл цуглуулан, анализ хийн тайланг боловсруулсан байна.	60.2%	616,273.0	370,947.0
20	ТХН үйл ажиллагааны зардал	2025		83.4%	1,448,468.9	1,208,241.1
	Нийт			16.4%	182,866,510.4	29,854,862.8

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн удирдах хорооны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 6 бараа, ажил, үйлчилгээг зээлээс 279,415,101.8 мянган төгрөг, буцалтгүй тусламжаас 6,253,967.4 мянган төгрөг, нийт 285,669,069.2 мянган төгрөгөөр баталсан байна. Төлөвлөгөөнд газар чөлөөлөх ажилд 37,250,641.0 мянган төгрөгийн зардал багтсан байна.

Горуулсанүйцэтгэлээр 1 ажлыг 37,323,056.1 мянган төгрөгөөр гэрээ байгуулж, 1 ажил гэрээ байгуулах шатанд, 1 ажил тендер шалгаруулах шатанд, газар чөлөөлөх ажилд 10,209,158.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Одончимэг, Чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 1/86 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 20,913,565.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 209,135.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төсвийн зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулж, тайлант онд гадаад, дотоод томилолтын зардал гараагүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн тансаг хэрэглээ, шаардлагагүй арга хэмжээний зардлыг танаж, төсвийн сахилга батыг сайжруулахад анхаарч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 4,530,176.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 167 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд хугацаа болоогүй 4 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 27,444,320.5 мянган төгрөгийн орлого, 35 удаагийн 26,160,749.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаас хоцорч, удаашралтай хэрэгжиж байгаагаас Зээлийн гэрээний 2.04-т "Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг /0.25 %/-тэй тэнцэх хэмжээгээр төлнө" гэсэн заалтын дагуу 1,270,380.43 ам.доллар буюу 4,530,176.6 мянган төгрөгийн хураамж төлж зээлийн хөрөнгийг үр ашиггүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зээлийн гэрээний 2.04-т "Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг /0.25 %/-тэй тэнцэх хэмжээгээр төлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр ашиггүй зарцуулалт гаргасан зөрчлийг таслан зогсоож, төслийн хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд хангах, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, гэрээний биелэлттэй холбоотой асуудал нь төсвийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын гэрээг Сангийн яамны зөвшөөрөл хүлээж хойшлуулан, 2026 оны 1 дүгээр сард гэрээ хийгдсэн учир завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 8,592,312.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 26,160.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	8,592,312.0	2	8,592,312.0	100.0
Зөвлөмж	1	26,160.4	1	26,160.4	100.0
Нийт дүн	3	8,618,472.4	3	8,618,472.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 575,911.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 551,953.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 23,958.2 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Мөнгөн хөрөнгийн 201900011830 тоот долларын дансны үлдэгдлийг 527,163.6 мянган төгрөгөөр, 201900011708 тоот дансны үлдэгдлийг 19,893.3 мянган төгрөгөөр тус тус ханшийн тэгшитгэлийг дутуу хийсэн;
- Мөнгөн хөрөнгийн 101900011831 тоот дансны гүйлгээ балансын дүн нь дансны үлдэгдлийн баталгааны дүнгээс 209.9 мянган төгрөг, 101900011830 тоот дансны үлдэгдэл 4,686.6 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй;

Залруулаагүй алдаа:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд 23,958.2 мянган төгрөгийн худалдан авалтыг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг аккруэл сууриар хөтөлж, худалдан авсан бараа материалын шинжтэй хөрөнгийг бараа материалын дансаар дамжуулан бүртгэх

Аудитаар илэрсэн 20,454.5 мянган төгрөгийн зөрчилд² 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 44,412.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 164,723.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/24 дугаар тушаалаар 1 ажилтныг Тээврийн ухаалаг системийн инженерээр 3-н сарын туршилтын хугацаагаар түр томилсон байна. Сангийн яамны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/3691 тоот албан бичгээр үндсэн мэргэжил болон ажлын туршлага нь тухайн ажлын байранд шаардлага хангахгүй байна хэмээн үзсэн учраас 5 дугаар сард ажлаас чөлөөлсөн байна. Ажилтны цалингийн зардалд 18,181.8 мянган төгрөг, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 2,272.7 мянган төгрөгийг шаардлага хангахгүй хүн ажилд томилж үр ашиггүй зарцуулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, цаашид ажлын байрны шаардлага хангасан албан тушаалтныг томилж байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн хөрөнгийн 201900011830 тоот долларын дансны үлдэгдлийг 527,163.6 мянган төгрөгөөр, 201900011708 тоот дансны үлдэгдлийг 19,893.3 мянган төгрөгөөр тус тус ханшийн тэгшитгэлийг дутуу хийсэн	1	547,056.9			1	547,056.9	1	547,056.9				
2	Мөнгөн хөрөнгийн 101900011831 тоот дансны гүйлгээ балансын дүн нь дансны үлдэгдлийн баталгааны дүнгээс 209.9 мянган төгрөгөөр, 101900011830 тоот дансны үлдэгдэл 4,686.6 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй	1	4,896.5			1	4,896.5	1	4,896.5				
3	Тайлант хугацаанд 23,958.2 мянган төгрөгийн худалдан авалтыг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлын дансанд бүртгэсэн байна	1	23,958.2			1	23,958.2			1	23,958.2	1	23,958.2
	Дүн	3	575,911.6			3	575,911.6	2	551,953.4	1	23,958.2	1	23,958.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/24 дугаар тушаалаар 1 ажилтныг Тээврийн ухаалаг системийн инженерээр 3-н сарын туршилтын хугацаагаар түр томилсон байна. Сангийн яамны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/3691 тоот албан бичгээр үндсэн мэргэжил болон ажлын туршлага нь тухайн ажлын байранд шаардлага хангахгүй байна хэмээн үзсэн учраас 5 дугаар сард ажлаас чөлөөлсөн байна. Ажилтны цалингийн зардалд 18,181.8 мянган төгрөг, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 2,272.7 мянган төгрөгийг шаардлага хангахгүй хүн ажилд томилж үр ашиггүй зарцуулсан байна.	1	20,454.5			1	20,454.5				
Дүн		1	20,454.5	0	0.0	1	20,454.5	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Тус төслийн хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаас хоцорч, удаашралтай хэрэгжиж байгаагаас Зээлийн гэрээний 2.04-т "Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг /0.25 %/-тэй тэнцэх хэмжээгээр төлнө" гэсэн заалтын дагуу 1,270,380.43 ам.доллар буюу 4,530,176.6 мянган төгрөгийн хураамж төлж зээлийн хөрөнгийг үр ашиггүйгээр зарцуулсан байна.	1	4,530,176.6	1	4,530,176.6				
	Нийт дүн	1	4,530,176.6	1	4,530,176.6	0	0.0	0	0.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 229/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/60/НА-СТА-ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын тогтвортой зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/24 дугаар тушаалаар 1 ажилтныг Тээврийн ухаалаг системийн инженерээр 3-н сарын туршилтын хугацаагаар түр томилсон байна. Сангийн яамны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/3691 тоот албан бичгээр үндсэн мэргэжил болон ажлын туршлага нь тухайн ажлын байранд шаардлага хангахгүй байна хэмээн үзсэн учраас 5 дугаар сард ажлаас чөлөөлсөн байна. Ажилтны цалингийн зардалд 18,181,800.00 /арван найман сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун/ төгрөг, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 2,272,700.00 /хоёр сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун/ төгрөг нийт 20,454,500.00 /хорин сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг шаардлага хангахгүй хүн ажилд томилж үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, цаашид ажлын байрны шаардлага хангасан албан тушаалтныг томилж байх биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар хотын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Б.Баатарзориг/, санхүүгийн ажилтан /Д.Болормаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-56.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 828/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/60/НА-СТА-ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын тогтвортой зам, тээвэр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төслийн хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаас хоцорч, удаашралтай хэрэгжиж байгаагаас Зээлийн гэрээний 2.04-т "Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг /0.25 %/-тэй тэнцэх хэмжээгээр төлнө" гэсэн заалтын дагуу 1,270,380.43 ам.доллар буюу 4,530,176,613.00 /дөрвөн тэрбум таван зуун гучин сая нэг зуун далан зургаан мянга зургаан зуун арван гурван/ төгрөгийн хураамж төлж зээлийн хөрөнгийг үр ашиггүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зээлийн гэрээний 2.04-т "Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг /0.25 %/-тэй тэнцэх хэмжээгээр төлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үр ашиггүй зарцуулалт гаргасан зөрчлийг таслан зогсоож, төслийн хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд хангах, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар хотын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Б.Баатарзориг/, санхүүгийн ажилтан /Д.Болормаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230